



ӨВӨРХАНГАЙ ЛЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/07

Хужирт сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын "Засаг даргын Тамгын газрын шатахуун, шатах тослох материал нийлүүлэх ӨВАХУСЗДТГ/202301024" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Цэдэв - Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга: Б.Бямбасүрэн - Байгаль орчны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Д.Уранчимэг - Санхүүгийн албаны дарга
Д.Мөнхбат - Бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн
Д.Норов - Иргэний төлөөлөл (зөвшилцснөөр)

2. Худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж, нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга (Л.Цэдэв)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж Засаг даргын Тамгын газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Бямбасүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301013

D:Alban bichig;Zahiramj 2023